

UCS 0302B:2025

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТ




Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын
ерөнхий шаардлага

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТ

Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын
ерөнхий шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 25/05-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	4
2. Норматив эшлэл.....	4
3. Нэр томьёо, тодорхойлолт	4
4. Оршуулгын газрын орчны ерөнхий шаардлага	5
5. Эрүүл ахуйн шаардлага	16
6. Анхаарах болон хориглох зүйлс.....	18
7. Шалгах хуудас	20
Ашигласан материал	21

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Оршуулгын газрын төлөвлөлтийн тойм зураг	5
Схем 1. Оршуулгын газрын төлөвлөлт	6
Зураг 2. Чандарлах оршуулгын гаднах дурсгалын самбар	7
Зураг 3. Зүлгэн оршуулгын газрын талбайн харагдах байдал	7
Зураг 4. Дурсамжийн самбар.....	8
Зураг 5. Оршуулгын газрын гадна талбайн төлөвлөлтийн чандарлах оршуулга	9
Зураг 6. Ногоон байгууламжийн төлөвлөлт	10
Зураг 7. Авто зогсоолын төлөвлөлтийг хийх загвар.....	10
Зураг 8. Төлөвлөлтийн план.....	11
Зураг 9. Гадна байгууламж	11
Зураг 10. Шарилын хөшөө	12
Зураг 11. Төлөвлөлтийн план.....	12
Зураг 12. Орц гарцын төлөвлөлт.....	14
Зураг 13. Чиглэлийн тэмдэг	15
Зураг 14. Чиглэлийн тэмдэг, ангилал	16
Зураг 15. Усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл	17
Зураг 16. Оршуулга ногоон байгууламжийн зохилдлогоо	18
Зураг 17. Ногоон байгууламжийн зохилдлогоо, ургалтын байдал.....	19

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Камер төлөвлөхөд шаардагдах мэдээлэл.....	19
Хүснэгт 2. Шалгуур үзүүлэлт	20



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 25/05

Улаанбаатар хот

Хот төлөвлөлт, хот байгуулалтад
хамаарах хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн “Хот төлөвлөлт, хот байгуулалт” бүлэгт хамаарах дор дурдсан хотын стандартуудыг хавсралтаар баталсугай.

1.1. UCS0302B:2025 “Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага” хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS0303B:2025 “Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага” хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

1.3. UCS0304B:2025 “Улаанбаатар хотын зуслангийн бүс, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн зэрлэг амьтдад ээлтэй хашаанд тавих ерөнхий шаардлага” хотын стандартыг гуравдугаар хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн хороо (Л.Ариунтуяа)-д даалгасугай.

ДАРГА



А.БАЯР

17.06.25

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 2705
дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТ

UCS 0302B:2025

“ОРШУУЛГЫН ГАЗРЫН ОРЧНЫ ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг нийслэл Улаанбаатар хотод оршуулгын газар төлөвлөх, байгуулах, хамгаалах, арчлах, дахин ашиглах, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр шарил чандарлах, зэрэг үйл ажиллагаанд хамаарна.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандартад эш татсан дараах хууль, журам, норм дүрэм, стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн эх материалыг үндэслэл болгоно.

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Газрын тухай хууль;
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- Хог хаягдлын тухай хууль;
- Эрүүл мэндийн тухай хууль;
- Оршуулгын үйл ажиллагаа эрхлэх, зохион байгуулах, зөвшөөрөлтэй оршуулгын газар болон зөвшөөрөлгүй газар оршуулсан шарилыг шилжүүлэх журам;
- MNS 5105:2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага;
- MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ;
- MNS 6841:2020 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Оршуулгад хамаарах үйлчилгээ. Ерөнхий шаардлага;
- MNS 5605:2006 Шарил чандарлах үйлчилгээний байгууллагад тавигдах ерөнхий шаардлага;
- MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлт, бохирдлыг үнэлэх;
- БНБД 30-01-04 Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Оршуулгын цогцолбор – гэж энэхүү стандартаар тогтоосон шаардлагад бүрэн нийцсэн дэд бүтэц, барилга байгууламж, ерөнхий төлөвлөлт бүхий мэргэшсэн байгууллагын удирдамж дор үйл ажиллагаа явуулах газар нутгийг;

Хаагдсан оршуулгын газар – гэж эрх бүхий байгууллагын шийдвэрээр оршуулгын үйл ажиллагаа явуулах буюу оршуулах/оршоохыг хориглосон газрыг;

Зөвшөөрөлгүй оршуулгын газар – гэж төрийн ба орон нутгийн захиргааны байгууллагад

бүртгэгдээгүй, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу олгосон газраас өөр газарт оршоосон газар нутгийг;

Шилжүүлсэн оршуулга – гэж зөвшөөрөлтэй оршуулгын газраас бусад газарт далд оршуулсан болон ил тавьсан шарилыг шилжүүлэн байршуулсныг;

Эрдэсжих – гэж оршуулсан шарил, цогцос химийн элемент ба энгийн химийн нэгдэл болон задрах үйл явцыг;

Оршуулгын байгууламж – гэж шарил, чандрыг газар дээр болон доор оршоох зорилгоор бүтээсэн байгууламжийг;

Дурсгалын барилга байгууламж – гэж тухайлсан түүхэн үйл явдал, хүнд зориулсан дурсгалын биет байгууламж бүхий бүтээлийг;


Зүлгэн оршуулгын газар – гэж талбайд бүхэлдээ ямар нэгэн мод бут тарихгүй, зөвхөн зүлэгжүүлсэн талбайг;

Чандарлах – гэж шарилыг зориулалтын зууханд шатааж үнс болгох технологийн үйл явцыг хэлнэ.

4. ОРШУУЛГЫН ГАЗРЫН ОРЧНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

4.1. Оршуулгын газрыг хүн амын нягтрал ихтэй, барилгажсан суурин газраас 20км-ээс багагүй зайд төлөвлөх нь тохиромжтой.

4.2. Хүн амын ундны усны аюулгүй байдал, хөрс болон агаарын бохирдлыг үүсгэх магадлалтай тул Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.5 дахь заалтын шаардлагад нийцүүлэн дараах байдлаар төлөвлөвөл зохино.




Зураг 1. Оршуулгын газрын төлөвлөлтийн тойм зураг

4.3. Оршуулга нь дараах төрлүүдтэй байж болно. Үүнд:

- Иргэний;
- Цэргийн;
- Төрийн;
- Шашны зан үйлийн;
- Үндэстний;
- Гамшиг, онцгой байдлын.

- 4.4. Оршуулгын газар нь хилийн булангийн цэгийг тогтоосон шав тэмдэгтэй, газрын зөвшөөрөлтэй, гэрчилгээгээр баталгаажсан, хариуцах этгээдтэй байхаас гадна Газрын тухай хуулийн 3.1.7 дах заалтын дагуу хилийн булангийн цэгийг тогтоосон шав тэмдэгтэй, газар эзэмших эрхийн гэрчилгээтэй байна.
- 4.5. Чандарлах: Оршуулгын газрын тодорхой хэсгийг чандарласан шарилыг байрлуулах зориулалттай болгон төлөвлөж болно. Эдгээр газрууд нь уламжлалт оршуулгын газартай төстэй байхаар төлөвлөх бөгөөд дараах дүрмийг баримтална. Үүнд:
- 4.5.1. Хөшөөний чулуу нь 75 см өндөр 60 см өргөнөөс ихгүй байж болно. Суурь нь 60 см өргөн, 30 см гүнээс хэтрэхгүй байна.
 - 4.5.2. Дурсгалын хананд бумба байрлуулж болно.
 - 4.5.3. Мод болон төмрөөр хийсэн байнгын дурсгалыг хориглоно.
 - 4.5.4. Цэцэрлэгийн зориулалтаар талбай төлөвлөхгүй бөгөөд зүлэгжүүлсэн талбайд тарьж, ургуулж, байрлуулж болохгүй.
 - 4.5.5. Хашаа хийхийг хориглоно.
- 4.6. Оршуулгын газрын төлөвлөлтийг хийхдээ дараах схемд үзүүлсэн нөхцөлүүдийг харгалзан үзвэл зохино.



Схем 1. Оршуулгын газрын төлөвлөлт


- 4.7. Тухайн нийслэл, дүүргийн хөгжлийн хэтийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан нийцсэн байх шаардлагатай.



Зураг 2. Чандарлах оршуулгын гаднах дурсгалын самбар (жишээ зураг)

4.8. Зүлгэн оршуулгын газар: Зүлэгжүүлсэн оршуулгын газрын аль ч хэсэгт мод, бут сөөг тарихыг хориглох бөгөөд хамгаалалтын зурвас үүсгэх байдлаар оршуулгын газрыг тойруулж мод, бут сөөг тарьж байгалийн тэмдэглэгээг бий болгож болно.


4.8.1. Булшны талбайн зүлгийг зөвшөөрөлгүй засах, зүлэгжүүлсэн талбайд ямар нэгэн эд зүйл тавихыг хориглоно.



Зураг 3. Зүлгэн оршуулгын газрын талбайн харагдах байдал (жишээ зураг)

4.9. Уламжлалт оршуулгын газар: Энэ төрлийн оршуулгын төлөвлөлт хийхдээ дараахыг анхаарч үзнэ.

- 4.9.1. Оршуулгын газарт аль болох жигд байдлыг хангах үүднээс бүх дурсгал, дурсгалт газруудын байрлалыг төлөвлөнө.
- 4.9.2. Суурийн чулууны дээд гадаргуу нь эргэн тойрон дахь зүлгийн түвшнээс дор хаяж 2 см-ийн өндөрт байх.
- 4.9.3. Оршуулгын газарт байрлуулах булшны чулуунд талийгаачийн нэрийг чулууны $\frac{3}{4}$ -аас доошгүй зайд, чулууны нүүрэн талд газрын түвшнээс дор хаяж 7.5 см өндөрт сийлсэн байна. Дараах байдлаар байрлуулж болно.



Зураг 4. Дурсамжийн самбар (жишээ зураг)

4.10. Нэг шарил (цогцос)-ыг далд оршуулахад ноогдох газрын хэмжээ 10м.кв-аас 20м.кв байх ба үүнд шарил хоорондын зай багтсан байх;


Оршуулгын газрын байршил, талбайн хэмжээ, хил зааг, хамгаалалтын бүсийг тухайн газрын байгалийн онцлог шинжээс хамаарч, орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтооно. Ингэхдээ оршуулгын газрын байршлыг төрийн зохицуулалтын хувьд гоо зүй, эрүүл мэнд, эд хөрөнгийн үнэ цэнийг /газар, бусад эд хөрөнгө/ харгалзан үзвэл зохино.

4.11. Оршуулгын газрын үйл ажиллагааны бүс хязгаарыг шаардлага хангасан хашаа, хаалтаар зааглаж, таних тэмдэг, хаяг бичвэр байрлуулах ба UCS 1001A:2023 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх арга зүйн удирдамж хотын стандартын шаардлагыг төлөвлөлтөд заавал тусгана.

4.12. Оршуулгын газрын үйл ажиллагааны бүсэд явган хүн, авто тээврийн хэрэгсэл нэвтрэх орц, гарц, тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоол, зан үйл гүйцэтгэх байгууламж, ариун цэврийн байгууламж, ногоон байгууламж, цогцос оршуулах /оршоох талбай/ байгууламж зэргийг тухайн газар нутгийн онцлогт тохируулсан байна.

4.13. Оршуулгын газарт оршуулгын цогц үйлчилгээ үзүүлэх байгууллага нь хэрэглэгчдэд шаардлагатай дараах дэд бүтцийг тусгасан байна. Үүнд:


- Орц, гарц;
- Авто зогсоол;
- Далд оршуулгын газар;
- Шарил чандарлах газар;
- Зан үйлийн танхим;
- Бунхан;
- Суварга;
- Ариун цэврийн байгууламж;
- Ногоон байгууламж.



- | | | |
|--|--------------------------------|---|
| ① Газар доорх оршуулга | ⑤ Зан үйлийн байгууламж | ⑨ Чандрын байгууламж |
| ② Газар доорх оршуулга урьдчилан төлөвлөгөөт | ⑥ Хяналтын пост | ⑩ Хашаа |
| ③ Бүртгэл | ⑦ Үйлчлүүлэгчдийн авто зогсоол | ⑪ Ногоон байгууламж |
| ④ Шарил хадгалах байгууламж | ⑧ Чандрын ханан байгууламж | ⑫ Инженерийн дэд бүтцийн барилга байгууламж |


Зураг 5. Оршуулгын газрын гадна талбайн төлөвлөлтийн чандарлах оршуулга (жишээ зураг)

- 4.14. Оршуулгын газрын хамгаалалтын бүсийг оршуулгын газраас 300 м, хот суурин газар, цэвэр ус, булаг шандын эх, аялал жуулчлалын бүсээс 200 м-ээс доошгүй зайд байхаар төлөвлөнө. Оршуулгын газрын хашаанаас 1000 метрээс багагүй зайд эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтооно.
- 4.15. Оршуулгын газрын нийт талбайн 20-оос доошгүй хувьд ногоон байгууламжтай байна. Мөн оршуулгын газрын хамгаалалтын бүсийн дагуу мод тарьж байгалийн тэмдэглэгээг бий болговол зохино.




Зураг 6. Ногоон байгууламжийн төлөвлөлт (жишээ зураг)

- 4.16. Оршуулгын газрын гадна талд тээврийн хэрэгслийн зогсоолыг UCS0902B:2022 “Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавих ерөнхий шаардлага” хотын стандартын дагуу хамгийн багадаа 50 автомашины зогсоолын хүчин чадалтайгаар төлөвлөнө.
- 4.17. Оршуулгын газрын эдэлбэр газарт явган хүний зам, тохижилтыг UCS0901B:2022 “Явган хүний зам талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага” хотын стандартын дагуу дараах байдлаар төлөвлөнө.




Зураг 7. Авто зогсоолын төлөвлөлтийг хийх загвар (жишээ зураг)



Зураг 8. Төлөвлөлтийн план (жишээ зураг)

- 4.18. Үйлчилгээний мэдээллийг агуулсан 50х50см-ээс багагүй хэмжээтэй самбарыг орцны хэсэгт байрлуулсан байна. (Оршуулгын газрын ерөнхий төлөвлөгөөний схем зургийг самбар хэлбэрээр гадна талбайд байрлуулна) Гадна талбайн гэрэлтүүлгийг UCS1902A:2022 “Гэрэлтүүлэх төхөөрөмжийг төлөвлөх, байрлуулах, суурилуулах удирдамж” хотын стандартын дагуу байрлуулсан байх шаардлагатай.
- 4.19. Гадна талбайд хогийн савыг UCS1406B:2022 “Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулах хогийн саванд тавих шаардлага”-ын дагуу байрлуулна. Аюултай хог хаягдлын ангилал, шаардлага хангасан хогийн савыг холбогдох стандартын баримт бичигт заасны дагуу төлөвлөн байрлуулна.
- 4.20. Оршуулгын байгууламжид тавигдах шаардлага
- 4.20.1. Оршуулгын байгууламж нь газар дээр ба доор сүм, суварга, бунхан, ханан байгууламж, хөшөө дурсгалын гэх мэт байгууламж байж болно.
- 4.20.2. Булшны нүх нь газрын гадаргаас 1.5м-ээс ихгүй гүнтэй, налуу бус эгц доошоо ухагдсан байх ба шарил хоорондын зай 2м-ээс ихгүй (булангийн ирмэгээс хэмжсэнээр) байна.
- 4.20.3. Зэргэлдээ орших булшинд хүндэтгэлтэй хандаж дундын зай бүхий орчныг цэвэр байлгана.



Зураг 9. Гадна байгууламж (жишээ зураг)

- 4.20.4 Шарилын хөшөө: Нас барсан хүний тухай дурсамжийг хадгалах зорилготой дурсгалын мэдээлэл агуулсан хөшөө, баримал, чулуу зэргийг байрлуулахаар төлөвлөж болно.

The Baby Garden

This is a place of quiet reflection and remembrance for families who have lost very young, premature or stillborn babies.

As it is a communal area, we try to consider the needs and wishes of the many families who go there to remember their loved ones.

There is a patio with seating, where people can place small items such as toys and ornaments, as we appreciate some families find comfort in placing personal keepsakes in the garden.

Rose bushes and vase blocks are available and there is a dedicated Baby Book of Remembrance in which families may place an entry on request without charge. This is on display in the Book of Remembrance Room.

We provide guidance on what items can be left and ask that only garden or fresh cut flowers are placed on the grassed burial area. We carry out checks to ensure that ornaments and toys are not broken or damaged so that visitors cannot be hurt and maintenance duties can be carried out.

If an item is broken or could be unsafe, we remove them. Ornaments that are stored behind the cemetery office for families to collect. All cemetery fees are waived for a burial in the Baby Garden.



Typical Zoning Requirements

Minimum lot sizes. Some communities establish minimum lot sizes for cemeteries. Typical is Fayette County, Georgia's requirement of one acre for a human cemetery and five acres for a pet cemetery.

Setback provisions. Many regulations establish a minimum distance between cemetery buildings and grave sites and the cemetery's property lines.

Appurtenances and Associated Land Uses. Cemeteries often include accessory uses or structures, such as mausoleums, storage vaults, chapels, and columbaria. In some areas, retail uses such as flower shops, refreshment sales, and related trades may be appropriate. Crematoria may or may not be associated with the location of the cemetery and may be subject to less oversight if located away from them. Many zoning regulations allow them as permitted uses in industrial zones. In some cases, crematoria may be more appropriately associated with funeral homes and related services.

Design Review. Communities may include special design criteria for historic cemeteries. For example, Atlanta's Georgian Oakland Cemetery Landmark District zoning regulation is intended "to ensure that future development and maintenance considerations are sensitive to and compatible with the unique character of this irreplaceable portion of Atlanta's heritage and to preserve Oakland Cemetery as a park-like oasis for passive recreation in this 19th century sculpture garden."

Other Requirements. As we've noted, in addition to zoning ordinance criteria, cemeteries typically need to meet other state and local requirements, often focused on ensuring public health. Some communities also require the local governing body to specifically approve any new or expanded cemeteries.

Зураг 10. Шарилын хөшөө (жишээ зураг)


4.20.5. Хөшөө, дурсгалын байгууламжийн овор хэмжээ, зай талбайг тухайн газар нутгийн газарзүйн тогтоц, байгалийн онцлог, зан заншилд тохируулан тодорхой хязгаарлалт хэмжээг орон нутгийн эрх бүхий байгууллагаас тогтоогоогүй тохиолдолд олгосон газарт багтаан байрлуулахаар төлөвлөлтийг хийнэ.

4.20.6. Байгалийн чулууг ашиглах тохиолдолд тухайн газар орны цаг уур, хөрсний шинж чанараас шалтгаалан хүндийн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх.

4.21. Булшны талбайн төлөвлөлтийг хийхдээ дараахыг харгалзан үзнэ. Үүнд:

4.21.1. Насанд хүрэгчдийн булшны талбайн хувьд хэмжээ нь 1м өргөнтэй, 2-2.5 метр урттай байна. Хүүхэд болон нялхсын булшны талбайн хувьд хэмжээ 1м өргөнтэй, 1.5м урттай;

4.21.2. Насанд хүрэгчдийн талбайн хувьд жийргэвчний хэмжээс нь 1.2м өргөнтэй, 3м урттай байна. Хаалтын өнгө нь саарал эсвэл цагаан өнгөтэй байна.



Газар дээр ил гарах булшны хаалтны
олон улсын стандартын хэмжээ
/хэрэв нэг доор 2 буюу түүнээс дээш тоотой үед/

Зураг 11. Төлөвлөлтийн план (жишээ зураг)

4.22. Хөшөө байрлуулах төлөвлөлт: Хөшөө нь суурин дээр байх ёстой. Хөшөө, суурийн нийт хэмжээг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- Том хөшөө дурсгалууд: 60-110 см урт, 20-30 см өргөн, 30-90 см өндөр;
- Жижиг дурсгалууд: 60-110 см урт, 20-30 см өргөн, 30 см хүртэл өндөр.

4.22.1. Хөшөө, суурь нь бетон суурь дээр тулгуурлана. Тулгуур нь суурийн периметрээс 10 см урт байна. Том хөшөөг 120 см-ийн гүнд, жижиг хөшөөг 60 см-ын гүнд суурилуулахаар бэлтгэгдсэн байна. Суурь нь өөр булшинд хүрч болохгүй. Хөшөөг булшны төгсгөлөөс унших боломжтой байхаар хийх шаардлагатай.

4.23. Хашаа: Оршуулгын газрыг харах боломжтой буюу нэвт харагддаг байхаар хашааг хийнэ.


4.23.1. Оршуулгын газрын хашаанд дараах шаардлагыг хангуулсан байна. Үүнд:

- Өндөр нь 2 метрээс багагүй хэмжээтэй байх;
- Багануудын хоорондох зай нь 2.5 метрээс хэтрэхгүй байх ёстой;
- Гинжин хэлхээтэй хашлага нь дараах өнгөтэй байна.

а. Саарал;

б. Хар;

с. Цагаан.



Зураг 12. Орц гарцын төлөвлөлт (жишээ зураг)


4.23.2. Оршуулгын газар нь өөр оршуулгын газартай хиллэдэг бол оршуулгын газруудын хооронд явган хүний хөдөлгөөнийг хангах үүднээс хашаанд хаалга суурилуулна.

4.23.3. Давхар гогцоотой буржгар утсан (нэхмэл утас) хашаа барихад дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:


- Хашааны өндөр нь 75-120 см-ийн хооронд байна;
- Хашааны тулгуур нь 2 метрийн хэмжээтэй, хуш модон материалтай байна;
- Гадаснууд хоорондоо 2.5 метрээс илүүгүй зайтай байна;
- Хөндлөвч нь хамгийн багадаа 2 метрт 60 см байх ёстой;
- Хөндлөвчинд утсыг хүнд даацын ац хадаасаар бэхэлнэ;
- Гадасны гүн нь хамгийн багадаа 75 см байна. Доод талыг нь 15-20 см хүртэл вандуйн хайргаар хийж, түүн дээр 60 см цементээр дүүргэнэ.

4.23.4. Чиглэл заасан таних тэмдгүүдийг дараах байдлаар төлөвлөнө.

- Металл материалтай байна. Өнгөний схем нь цагаан үсэг бүхий бор дэвсгэртэй байна;
- Чиглэлийн тэмдэг нь замын тэмдгийн стандартыг хангасан байхаас гадна мэдээллийн тэмдэг нь 75-120 см-ээс ихгүй, тэгш өнцөгт хэлбэртэй байна.



Зураг 13. Чиглэлийн тэмдэг (жишээ зураг)



Зураг 14. Чиглэлийн тэмдэг, ангилал (жишээ зураг)


4.23.5. Хөшөөний тэмдэг: Хөшөөний бүх загвар, өнгө нь оршуулгын газраар батлагдсан байна (зарим тохиолдолд үүнд хувь хүний талбайн булшны хөшөө хамаарахгүй байж болно).

- Материал нь гантиг, бетон, боржин чулуу байх нь зохимжтой. Үсгийг сийлбэрлэсэн байна.
- Тэмдгийг аль болох бага байлгахыг зөвлөж байна, гэхдээ 2 метрийн зайнаас уншиж болохуйц байна.

5. ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА

5.1. Оршуулгын газрын хөрс, орчныг улирал тутам нэг удаа мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгэх ба жилд 2 удаа /хавар, намрын улиралд/ шавж, мэрэгч устгалын ажлыг хийлгэнэ. Шаардлагатай тохиолдолд тухай бүр нэмэлтээр хийлгэнэ.

Усны нөөцөд үзүүлэх оршуулгын газрын нөлөөг доорх жишээ зургаар үзүүлэв.



Түр зуурын эсвэл байнгын овгор шороо

Зураг 15. Усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл (жишээ зураг)

- 5.2. MNS3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлт, бохирдлыг үнэлэх стандартын 6.2 дахь хэсэгт заасны дагуу үйлчилгээ эрхэлж буй ААН, иргэн нь өөрийн өмч, эзэмшил, ашиглалтад байгаа газрын хөрснөөс жилд 2 удаа дээж авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлнэ.
- 5.3. MNS0900:2019 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандартын 5.5, 6.3 дэх заалтад заасны дагуу оршуулгын газрын ундны уснаас төвлөрсөн усан хангамжтай бол жилд 1 удаа, төвлөрсөн бус усан хангамжтай бол жилд 2 удаа дээжийг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж, дүгнэлт гаргуулна
- 5.4. Оршуулгын газарт төвлөрсөн бус ус хангамж ашиглах бол гүний худаг гаргах зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авах, зөөврийн усан хангамж ашиглах бол усны нөөцийн савыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар суурилуулах, угааж, халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байх.
- 5.5. UCS 1701A:2022 “Хог хаягдлын менежмент” бүлгийн хотын стандартын шаардлага хангасан хогийн цэгтэй, эрх бүхий байгууллагатай хийсэн хог хаягдлын гэрээтэй байх шаардлагатай.
- 5.6. Бие даасан инженерийн байгууламжаар бохир усаа шийдсэн бол бохирыг соруулах мэргэжлийн байгууллагатай гэрээтэй байх.
- 5.7. Бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй онцгой аюултай халдварт өвчнөөр нас барсан шарилыг салбар яамны сайдын баталсан дүрэм, журам тусгай шаардлагын дагуу оршуулна.

6. АНХААРАХ БОЛОН ХОРИГЛОХ ЗҮЙЛС


- 6.1. Оршуулгын газарт байрлах булшинд байрлалын дагуу нэгдсэн дугаар олгож мэдээллийн санд бүртгэнэ.
- 6.2. Оршуулгын газрын ерөнхий өнгө үзэмж, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлсөн барилга байгууламж барих, угсрах, нүүлгэхээс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 6.3. Мод, бут сөөг, ургамлыг гэмтээж, тээврийн хэрэгсэл жолоодохгүй, тогтоосон замаас бусад газарт машинаа зогсоож болохгүй.
- 6.4. Хөшөө дурсгалт байгууламжийн эргэн тойронд сурталчилгааны самбар, дэлгэц байрлуулахыг хориглоно. Оршуулгын газрын аль ч хэсэгт зар сурталчилгааны хэлбэрийг байрлуулахыг хориглоно.
- 6.5. Галын аюулгүй байдлыг хангахдаа Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-ийг баримтална.
- 6.6. Оршуулгын газарт ил гал гаргаж болохгүй, зөвхөн зориулалтын зөвшөөрөгдсөн хэсэгт зул өргөнө. Зул мандаах өргөөгүй газарт зул өргөхдөө битүүмжлэлтэй саванд өргөнө.
- 6.7. Уламжлалт оршуулгын газарт мод, төмөр, металл дурсгал, шахмалуудыг оршуулгын газарт оруулахыг хориглоно.
- 6.8. Арчилгааг дараах байдлаар хийнэ. Үүнд:
 - Арчилгаанд өвс хадах, тайрах, зам засварлах, хонхойсон булш, тэмдэглэгээг тэгшлэх, ургамал тарих зэрэг ажлууд багтана.
 - Байнгын арчилгаа нь тэмдэг, хөшөө дурсгал, суурийг засварлах, солих зэрэгт хамаарахгүй. Оршуулгын газрын талбай болон булшны зайд бут сөөг тайрах.
 - Хортой, цочромтгой, өргөстэй, жимсний мод, шүүс дусдаг ургамлыг сонгож болохгүй.
- 6.9. Хог хаягдал, хөл газрын ургамал (хог ургамал), хатсан цэцэг, ургамлыг хаях зориулалтын хогийн савтай байна.



Зураг 16. Оршуулга ногоон байгууламжийн зохилдлогоо (жишээ зураг)

- 6.10. Ургамал: Ургамлын өндөр 15-20 см байх.
 - 6.10.1. Нэг наст цэцэг, олон наст ургамлыг боржин чулуу, хар гантиг, цемент, ширмэн, удаан эдэлгээтэй хуванцраар хийсэн сав, варанд суулгана.
 - 6.10.2. Бүх сав, ваарыг сайн нөхцөлд хадгалах ёстой. Төмөр ваарыг зохих ёсоор будсан байх ёстой.
 - 6.10.3. Сарнайн бут, цахилдаг, хөндийн сараана болон арчилгаа их шаарддаг олон наст ургамлуудыг тарихыг хориглоно. Боломжтой бол тухайн бүс нутгийн уугуул ургамлуудыг сонгох нь арчилгаа бага шаарддаг бөгөөд

өвчин, шавжид тэсвэртэй байдаг. Хэрэв уугуул ургамлын төрөл зүйл хязгаарлагдмал бол тухайн бүс нутагт сайн зохицдог ургамлыг сонго. Энэ нь хөрсний давхаргын аэробик/агааргүй нөхцөл өөрчлөгдөхөд нөлөө үзүүлж, зарим давс, металлыг хадгалах, түр зуур тунадасжуулах явцад органик буюу бичил биетний бохирдуулагчийг бууруулж болзошгүй.



Зураг 17. Ногоон байгууламжийн зохилдлогоо, ургалтын байдал (жишээ зураг)

- 6.10.4. Оршуулгын газар нь хяналтын камертай байх ба суурилуулалтын өндөр нь 2.5м-5м байх нь зохимжтой. 2.5м өндөрт байрлуулсан хяналтын камер нь талбайг илүү ойр зайнаас харуулах бол 5м өндөрт байрлах нь эргэн тойрны талбайг илүү сайн хамруулж харуулдгийг анхаарах хэрэгтэй.
- 6.10.5. Камерыг булшны дэргэд байрлуулж болохгүй, камерын эргэлдэх чимээ нь булшийг эргэж очсон хүмүүст сонсогддог. Энэ нь хүмүүсийн нас барагсадтай салах ёс гүйцэтгэх, тэдний төлөө залбирахад саад болох тул тохиромжгүй.
- 6.10.6. Камерыг булшнаас тодорхой зайд, явган хүний зам дагуу гэрэлтүүлгийн шон дээр суурилуулах хэрэгтэй.

Хүснэгт 1. Камер төлөвлөхөд шаардагдах мэдээлэл

№	Байршил	Төрөл	Камерын тоо
1	Орох хаалга	Тоон эсвэл аналог	1
2	Зулах хаалга	Тоон эсвэл аналог	1
3	Орох хаалганы дагуу явган хүний зам	Тоон эсвэл аналог	1
4	Дугуйн зам	Тоон эсвэл аналог	1
5	Оршуулгын газрын төв цэг	Тоон эсвэл аналог	1

- 6.11. Хааж, нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн оршуулгыг газарт хаалтын төлөвлөгөө боловсруулсан байна.

7. ШАЛГАХ ХУУДАС

Хүснэгт 2. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Оршуулгын газрын эзэмшил газрын хилийг тэмдэгжүүлэн стандартын дагуу хашаа байрлуулсан эсэх	☐	☐
2	Оршуулгын газрын гадна талбайд тухайн барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөө, байршлын схем зургийг ойлгомжтойгоор самбарт байрлуулсан эсэх	☐	☐
3	Газарт оршоосон булшны чулууг дугаарлан холбогдох мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд хадгалсан эсэх	☐	☐
4	Оршуулгын газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоон тэмдэгжүүлэн анхааруулах тэмдгийг баримт бичгийн дагуу байрлуулсан эсэх	☐	☐
5	Оршуулгын газрын эзэмшил газарт бусад зориулалтын барилга байгууламж байрлуулсан эсэх	☐	☐
6	Орц гарцыг хотын стандартын баримт бичгийн дагуу төлөвлөсөн эсэх	☐	☐
7	Гэнэтийн аваар осол, байгалийн гамшгийн үед хэрэглэх аюулын зарлан мэдээлэх төхөөрөмж байрлуулсан эсэх	☐	☐
8	Тээврийн хэрэгслийн зогсоолыг баримт бичгийн дагуу төлөвлөсөн эсэх	☐	☐
9	Оршуулгын газрын орчмыг камержуулсан эсэх	☐	☐
10	Оршуулгын газрын гадна орчинд хотын стандартын баримт бичгийн дагуу гэрэлтүүлэг байрлуулсан эсэх	☐	☐
11	Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг хотын стандартын баримт бичгийн дагуу төлөвлөсөн эсэх	☐	☐
12	Халдваргүйжүүлэлтийг баримт бичигт заасан хугацаанд гүйцэтгэж тэмдэглэл хөтлөн баримтжуулдаг эсэх	☐	☐
13	Булш хоорондын зайг баримт бичигт заасны дагуу байрлуулсан эсэх	☐	☐
14	Булшны бүрэн бүтэн байдал алдагдсан тохиолдол бүрийг тэмдэглэн цаг алдалгүй засварлан баримтжуулдаг эсэх	☐	☐
15	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэдэг эсэх	☐	☐
16	Оршуулгын газрын хөрсийг жилд 1 удаа лабораторийн шинжилгээнд хамруулсан эсэх, шинжилгээний дүн, дүгнэлт байгаа эсэх.	☐	☐
17	Оршуулгын газрын ундны усыг лабораторийн шинжилгээнд шинжлүүлж, дүгнэлт гаргуулсан эсэх.	☐	☐
18	Ариун цэврийн байгууламж нь хүрэлцээтэй, эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан эсэх.	☐	☐

Тайлбар: Дээрх шалгуур үзүүлэлтийг хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Газрын тухай хууль;
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- Байгаль орчны тухай багц хууль;
- Оршуулгын үйл ажиллагаа эрхлэх, зохион байгуулах, зөвшөөрөлтэй оршуулгын газар болон зөвшөөрөлгүй газар оршуулсан шарилыг шилжүүлэх журам;
- MNS 5105:2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага;
- MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ;
- MNS 6841:2020 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Оршуулгад хамаарах үйлчилгээ. Ерөнхий шаардлага;
- MNS 5605:2006 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Шарил чандарлах үйлчилгээний байгууллагад тавих ерөнхий шаардлага;
- БНБД 30-01-04 Хот тосгоны төлөвлөлт, барилгажилт;
- Standard operating procedure-(sop) close circuit television (cctv) operation (security department –iobm);
- <https://alarconespinosa.com/2020/05/14/two-steps-that-should-be-followed-when-installing-security-cameras-in-cemeteries/>;
- <https://www.hastings.gov.uk/Cemetery-crematorium/grave-types/>;
- <https://www.dowr.org/img/Cemetery%20Rules%20and%20Regulations.pdf>;
- <https://www.codepublishing.com/WA/Roslyn/html/Roslyn12/Roslyn1245.html>.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын зам 1201,
Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор Б байр



72707700



www.uds.ub.gov.mn



Хот байгуулалт, хотын стандартын газар